



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 95

Мандалговь

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.6, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Гурвансайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2018 оны 13-07-016/35 дугаар дүгнэлтээр цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь тогтоогдсон 183,169,056 /нэг зуун наян гурван сая нэг зуун жаран есөн мянга тавин зургаа/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй хуучин сургуулийн 1972 онд ашиглалтанд орсон Соёлын төвийн барилга, 851,000 /найман зуун тавин нэгэн мянга/ төгрөгийн балансын үнэтэй, 179,655 /нэг зуун далан есөн мянга зургаан зуун тавин тав/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 2006 онд ашиглалтанд орсон Нүүрсний агуулах, 2,836,684 /хоёр сая найман зуун гучин зургаан мянга зургаан зуун наян дөрөв/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй 2008 онд ашиглалтанд орсон 6 настай хүүхдийн нойлыг тус тус акталж устгахыг зөвшөөрсүгэй.

Хоёр: Гурвансайхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Г.Найгалмаад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Сумын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, данснаас хасах, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг нөхөн сэргээж байгууллагын хэрэгцээнд зориулалтаар нь ашиглах

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 04 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

